



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/21/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот
2021он

Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч: Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: ganulzii.t@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Ш.Нарантуяа

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Гэрэлт хөхийн тэнцвэр
Аудит” ХХК

Утас: 9611-2118 Цахим хаяг: Gerelt.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
БОЯ	Байгаль Орчны Яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Агуулга

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Аудитын зөвлөмж:	<u>17</u>
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Ауд. ор. 25 № 16/177

танай _____ -ны № _____ -г

АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Д.СҮРЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ - Т.ГАН-ӨЛЗИЙ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,601,768.00	73,868,618.00
33	АВЛАГА	-	48,957,400.00
335	Бусад авлага	-	48,957,400.00
3351	Байгууллагаас авах авлага	-	48,957,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,601,768.00	24,911,218.00
354	Хангамжийн материал	8,601,768.00	24,911,218.00
35410	Бичиг хэргийн материал	973,150.00	957,750.00
35420	Аж ахуйн материал	5,057,618.00	19,754,468.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,120,000.00	1,329,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,451,000.00	2,825,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	45,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	130,165,913.82	151,670,509.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	130,165,913.82	151,670,509.56
392	Биет хөрөнгө	39,317,913.82	59,383,342.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,935,093.70	9,935,093.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,473,344.88)	(2,046,689.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,625,720.00	69,625,720.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(67,449,143.80)	(69,531,386.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,996,670.48	100,354,560.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	(68,228,708.32)	(78,988,039.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,109,791.00	14,259,791.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,121,224.70)	(9,403,866.45)
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,968,230.00	47,558,230.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,045,169.66)	(22,380,070.48)
393	Биет бус хөрөнгө	90,848,000.00	92,287,166.72
39301	Програм хангамж	200,000.00	1,927,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(200,000.00)	(487,833.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	90,848,000.00	90,848,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	138,767,681.82	225,539,127.56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	138,767,681.82	225,539,127.56
51	Засгийн газрын хувь оролцоо	138,767,681.82	225,539,127.56
512	Хуримтлагдсан үр дүн	(83,436,060.39)	13,150,830.66
51210	Өмнөх үеийн үр дүн	(73,620,615.08)	(73,620,615.08)
51220	Тайлант үеийн үр дүн	(9,815,445.31)	86,771,445.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,262,649.42	4,262,649.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	138,767,681.82	225,539,127.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	407,331,600.00	684,096,608.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,960,000.00	19,979,257.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,960,000.00	19,979,257.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,960,000.00	5,479,257.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,812,267.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	3,666,990.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө	-	14,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	404,371,600.00	664,117,351.76
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	92,057,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	43,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	48,957,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	572,059,951.76
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	572,059,951.76
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	416,152,045.31	597,325,163.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	416,152,045.31	597,325,163.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	413,265,122.87	546,864,763.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,525,475.56	170,690,260.72
210101	Үндсэн цалин	113,622,975.56	161,621,260.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	9,069,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,958,471.00	20,828,582.59
210201	Тэтгэврийн даатгал	11,069,667.00	14,540,901.30
210202	Тэтгэмжийн даатгал	1,245,275.00	1,710,693.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	995,943.00	1,355,118.97
210204	Ажилгүйдлийн даатгал	248,770.00	282,419.55
210205	Эрүүл мэндийн даатгал	2,398,816.00	2,939,449.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,178,724.00	4,336,282.45
210301	Гэрэл, цахилгаан	497,992.00	930,511.45
210302	Түлш, халаалт	3,210,389.00	2,739,542.00
210303	Цэвэр, бохир ус	470,343.00	666,229.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,179,153.00	75,116,451.00
210401	Бичиг хэрэг	737,414.00	1,676,970.00
210402	Тээвэр, шатахуун	8,071,466.00	58,894,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	913,268.00	893,154.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	126,200.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	330,805.00	463,227.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	13,045,000.00
2105	Нормативт зардал	495,000.00	429,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	495,000.00	429,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	938,450.00	8,559,600.00
210604	Урсгал засвар	724,350.00	8,559,600.00

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	3,509,000.00	1,205,800.00
210702	Дотоод албан томилолт	3,509,000.00	1,205,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,269,470.00	163,872,692.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	189,735,960.00	162,463,342.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	324,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	126,370.00	111,110.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,900.00	70,000.00
210807	Газрын төлбөр	801,900.00	904,240.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,211,379.31	101,826,094.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,970,134.00	80,135,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	740,000.00	370,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,501,245.31	21,320,294.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,886,922.44	50,460,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,453,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,453,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,886,922.44	50,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,886,922.44	50,000.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		48,957,400.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(8,820,445.31)	86,771,445.74
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(8,820,445.31)	86,771,445.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	407,331,600.00	665,929,618.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,960,000.00	1,812,267.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,960,000.00	1,812,267.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,960,000.00	1,812,267.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,960,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,812,267.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	404,371,600.00	664,117,351.76
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	404,371,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	404,371,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	92,057,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	43,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	48,957,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	572,059,951.76
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	572,059,951.76
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	405,427,900.00	641,271,718.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	405,427,900.00	641,271,718.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	401,040,977.56	590,811,318.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,525,475.56	170,690,269.35
210101	Үндсэн цалин	113,622,975.56	157,883,003.35
210102	Нэмэгдэл	10,902,500.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	12,807,266.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,953,471.00	20,828,573.96
210201	Тэтгэврийн даатгал	11,069,667.00	15,399,054.64
210202	Тэтгэмжийн даатгал	1,245,275.00	1,470,112.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	995,943.00	895,246.73
210204	Ажилгүйдлийн даатгал	248,770.00	594,702.07
210205	Эрүүл мэндийн даатгал	2,393,816.00	2,469,457.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,178,724.00	4,844,412.45
210301	Гэрэл, цахилгаан	497,992.00	900,083.45
210302	Түлш, халаалт	3,210,389.00	3,278,100.00
210303	Цэвэр, бохир ус	470,343.00	666,229.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,149,787.00	23,004,881.00
210401	Бичиг хэрэг	638,314.00	639,500.00
210402	Тээвэр, шатахуун	8,150,000.00	20,850,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	913,268.00	893,154.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	126,200.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	322,005.00	478,227.00

**Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2105	Нормативт зардал	495,000.00	495,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	495,000.00	495,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,428,450.00	9,784,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	414,100.00	1,060,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	60,000.00	-
210604	Урсгал засвар	954,350.00	8,724,100.00
2107	Томилолт, зочны зардал	3,509,000.00	1,205,800.00
210702	Дотоод албан томилолт	3,509,000.00	1,205,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,347,870.00	279,301,842.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,814,360.00	277,892,492.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,340.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	126,370.00	111,110.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,900.00	70,000.00
210807	Газрын төлбөр	801,900.00	904,240.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,453,200.00	80,655,740.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,713,200.00	80,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	740,000.00	655,740.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,386,922.44	50,460,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,453,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,453,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,886,922.44	49,007,400.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,886,922.44	50,000.00
213404	Хөрөнгийн		
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		48,957,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,903,700.00</u>	<u>24,657,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	24,657,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	24,657,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	24,657,900.00
222001	Тоног төхөөрөмж	-	917,900.00
223001	Бусад хөрөнгө	-1903,700.00	23,740,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(24,657,900.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,125,647.48	4,262,649.42	(63,805,169.77)	148,583,127.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,125,647.48	4,262,649.42	(63,805,169.77)	148,583,127.13
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(9,815,445.31)	(9,815,445.31)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,125,647.48	4,262,649.42	(73,620,615.08)	138,767,681.82
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	208,125,647.48	4,262,649.42	(73,620,615.08)	138,767,681.82
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,125,647.48	4,262,649.42	(73,620,615.08)	138,767,681.82
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	86,771,445.74	86,771,445.74
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,125,647.48	4,262,649.42	13,150,830.66	225,539,127.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	711,959,800.00	573,822,218.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	711,959,800.00	573,822,218.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	709,959,800.00	572,369,218.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,291,800.00	170,690,269.35
210101	Үндсэн цалин	176,451,800.00	157,883,003.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,840,000.00	12,807,266.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,036,500.00	20,828,573.96
210201	Тэтгэврийн даатгал	16,344,900.00	15,399,054.64
210202	Тэтгэмжийн даатгал	1,922,900.00	1,470,112.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,538,300.00	895,246.73
210204	Ажилгүйдлийн даатгал	384,600.00	594,702.07
210205	Эрүүл мэндийн даатгал	3,845,800.00	2,469,457.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,446,200.00	4,844,412.45
210301	Гэрэл, цахилгаан	1,153,600.00	900,083.45
210302	Түлш, халаалт	3,278,100.00	3,278,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,014,500.00	666,229.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,945,800.00	11,934,881.00
210401	Бичиг хэрэг	639,500.00	639,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,782,600.00	9,780,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,100.00	893,154.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	479,600.00	478,227.00
2105	Нормативт зардал	495,000.00	495,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	495,000.00	495,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,167,300.00	9,144,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	420,700.00	420,700.00
210604	Урсгал засвар	8,746,600.00	8,724,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,989,600.00	1,205,800.00
210702	Дотоод албан томилолт	2,989,600.00	1,205,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	382,845,100.00	272,569,742.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	380,756,200.00	271,160,392.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	360,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	318,000.00	111,110.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	70,000.00
210807	Газрын төлбөр	1,006,900.00	904,240.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,742,500.00	80,655,740.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,000,000.00	80,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	742,500.00	655,740.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,453,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,453,000.00

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,453,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	711,959,800.00	573,822,218.76
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	709,959,800.00	572,009,951.76
132001	Орон нутгийн төсвөөс	709,959,800.00	572,009,951.76
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	1,812,267.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	1,812,267.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	14.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөгөөр/
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,057,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,057,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,070,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,070,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,130,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,130,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,900,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,900,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,957,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	48,957,400.00
213404	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	48,957,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	92,057,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,057,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,957,400.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Д.Сүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Ж.Ням-Осор, аудитор Ш.Нарантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Экосистемийн даацад тохируулан Тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагаа олон нийтийн оролцоог чиглүүлэн байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тус газрын зорилго оршино.

Тайлант хугацаанд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/87 тоот тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажилласан байна.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх өөрчлөлт;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д” Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”.(2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн)
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д” Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална” (2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)
- Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны 382 дугаар тогтоолын 5-д “Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл хөлс, төрийн үйлчилгээний албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож олгосугай.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн шууд захирагч нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 548,367.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10,967.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 86,771.4 мянган төгрөгөөр буюу 38.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын дансанд материаллаг өөрчлөлт гарсан данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	0	48,957.4	48,957.4
Урьдчилгаа			-
Бараа материал	8,601.7	24,911.2	16,309.4
Үндсэн хөрөнгө	130,165.9	151,670.4	21,504.5
Нийт хөрөнгө	138,767.6	225,539.1	86,771.4
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	138,767.6	225,539.1	86,771.4
Хуримтлагдсан үр дүн	-83,436.0	13,150.8	-96,586.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	138,767.6	225,539.1	86,771.4

Төсөвт байгууллага нь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлдэг учир мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын тайлангийн үлдэгдэл 24,911.2 мянган төгрөг болж 16,309.4 мянган төгрөг болж өссөн нь түлш шатах тослох материал 1,374.0 мянга, сэлбэг хэрэгсэл 209.2 мянга, аж ахуйн материал 14,696.8 мянган төгрөгөөр өссөнөөс нөлөөлсөн байна.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 140,012.9 мянган төгрөгөөр буурсан. Өөрийн хөрөнгөөр 24,657.9 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө худалдан байна.

Биет бус хөрөнгийн дансанд 2020 оны тайлант хугацаанд ямар нэгэн материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 225,539.1 мянган төгрөг болж 86,771.4 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн өссөнөөс шалтгаалжээ. Энэ нь тайлант оны элэгдлийн зардал болон үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

2020 оны мөнгөн гүйлгээний тайлангаар нийт орлого өмнөх оноос 258,598.0 мянган төгрөгөөр буюу 38 хувиар өссөн байна. Нийт зардал өмнөх оноос 186,886.4 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 711,459.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 711,459.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 137,637.6 мянган төгрөгөөр бууруулж, 573,822.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөр, хоёр арга хэмжээг санхүүжүүлэхээр 711,459.8 мянган төгрөгийн төсөв улсын төсвөөс баталж санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилтийг бүрэн авч 573,822.2 мянган төгрөгийг зарцуулж 50.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

№	Зардлын бүлгийн код	Зардлын бүлгийн нэр	2020 оны батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү (+,-)
Урсгал зардлын тооцоо					
1	2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	192,291,800.0	170,690,269.4	21,601,530.7
2	2102	Ажил олгогчоос олгох НДШ	24,036,500.0	20,828,574.0	3,207,926.0
3	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,446,200.0	4,844,412.5	601,787.6
4	2104	Хангамж, бараа материалын зардал	11,945,800.0	11,934,881.0	10,919.0
5	2105	Нормативт зардал	495,000.0	495,000.0	
6	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,167,300.0	9,144,800.0	22,500.0
7	2107	Томилолт зочны зардал	2,989,600.0	1,205,800.0	1,783,800.0
8	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	382,845,100.0	272,569,742.0	110,275,358.0

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

9	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,742,500.0	80,655,740.0	86,760.0
10	2131	Гадаад урсгал шилжүүлэг			
11	2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.0	1,453,000.0	47,000.0

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 43,100.0 мянган төгрөг, Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 48,957.4 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлжээ.

Үүнээс Багаж техник хэрэгслийн зардалд 19,130.0 мянга, Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардалд 12,900.0 мянга, тээвэр шатахууны зардалд 11,070.0 мянга, нийт 43,100.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 2020 оны 149 мэдээллийг бүрэн мэдээлж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ил тодын самбарт нээлттэйгээр бүрэн байршуулсан байна.

Тус онд шилэн дансанд мэдээлэх 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар зөрчилгүй санал дүгнэлттэй ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 51,364.3 мянган төгрөгийн зөрчилд 51,364.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, УСНББОУС, НБББББ-ийн дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа гараагүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад алдаа, зөрчил илрээгүй.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 51,364.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий дахинд дэгдэж буй Ковид-19 халдварын нөхцөл байдлаас шалтгаалан 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагын эргэлтийн болон үндсэн хөрөнгөнд биет шалгалт хийгээгүй ба тухайн байгууллагын аудитад өгсөн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас түүвэрлэн шалгахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч нөхөн сэргээж цаашид ашиглах шаардлагатай хөрөнгүүд байна.

Мөн УСНББОУС-ын дагуу тооцоолсон цалингаар цалингийн өглөг үүсгээгүй, цалингийн зардалд шууд бичилт хийгдсэн байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй". заалтуудыг зөрчсөн.

4.1.2 Эрсдэл:

Хууль тогтоомжууд зөрчигдөж, татварыг нуун дарагдуулах боломжийг бусдад олгоно, татварын орлого дутуу бүрдэх;

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримттай бараа, үйлчилгээг авч байх, цаг тухайд цахим Е баримтыг хангуулан бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

ТШЗ-ын зүгээс хойшид анхаарч, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.25			ДГА-2021/21/СТА-ТШЗ
Шалгагдагч байгууллагын нэр:	Байгаль орчин, аялал жуулчлалын газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/.		Зөвлөмж хүргүүлэх	Дарга, Нягтлан бодогч	Д.Сүрэн, Б.Батзангиа
НИЙТ ДҮН					